



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,  
Утас: 264216, Факс: 264460,  
E-mail: info@csc.gov.mn

2024.04.15 № 03/742

таний -ны № -т

Г

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ ТАНАА

Г

Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 04 дүгээр  
сарын 10-ны өдрийн хуралдаанаар Дундговь аймаг  
дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт  
оруулах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.


Төрийн албаны зөвлөлийн 2024 оны “Салбар  
зөвлөлийн гишүүнээр томилох тухай” 114 дүгээр  
тогтоолыг хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.


ГИШҮҮН

БОР

БЛУРЭВДАГВА



24060605





МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

Г Салбар зөвлөлийн гишүүнээр томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь Салбар зөвлөлийн гишүүнээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Шагдарсүрэнгийн Энхсүх, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Нансалмаагийн Түвшинжаргал нарыг томилсугай.

2. Төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албаны шинэтгэл, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн гишүүн (Ш.Энхсүх, Н.Түвшинжаргал)-д үүрэг болгосугай.

3. Салбар зөвлөлийн гишүүнийг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь Салбар зөвлөлийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Доржбатад даалгасугай.

4. Энэхүү тогтоолыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (В.Жавзан)-д даалгасугай.

ДАРГА

Л.ЦЭДЭВСҮРЭН



24000264

